



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/167

Бат-Өлзий сум

Газар ашиглалтын зориулалт
өөрчлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутагт дэвсгэр, төв 1-105 тоотод “Элбэг констракшн” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж талбайн зориулалтаар эзэмшиж байгаа 6221002423 нэгж талбарын дугаартай 7114 м.кв газрын зориулалтыг нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэж, газар эзэмших эрхийн гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН